

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 25 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны есдүгээр 24-ний өдрийн 10 цаг 00 минутад эхэлж, 11 цаг 30 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 30 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Үндэсний статистикийн хороо, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Худалдан авах ажиллагааны газрын сул орон тоо нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"><li data-bbox="867 1226 1521 1625">1. Үндэсний статистикийн хороо, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Худалдан авах ажиллагааны газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 19 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх.<li data-bbox="867 1625 1521 1879">2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 4 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь

		<p>томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан, нэр бүхий 4 нэр дэвгшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа, холбооны газрын дарга /Ц.Жадамбаа/-д, Үндэсний статистикийн хорооны дарга /С.Мэндсайхан/-д, Худалдан авах ажиллагааны газрын дарга /Б.Энхжаргал/-д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь Салбар зөвлөлийн 2014 оны 35 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Балдандоржийн Итэшмааг 2014 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013</p>

		<p>оны 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 5-д "...Рагчаагийн Пүрэвдорж" гэснийг "...Балдандоржийн Итэшмаа" гэж өөрчлөх.</p> <p>3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Итэшмаад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газарт ажиллаж байсан ахлах мэргэжилтэн, Б.Ундармаа, ахлах байцаагч Л.Оюунбилэг нараас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Гадаад харилцааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр ажиллаж байсан Б.Ундармаагаас тус агентлагт төрийн албаны шалгалт өгч тэнцээгүй Э.Хулан, туслах түшмэлийн албан тушаалд шалгалт өгч тэнцсэн Ч.Гантуяа нарыг үндсэн орон тооны ажилтан гэж үзэж, хууль бусаар ажиллуулсан гэх өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.6-д заасныг удирдлага болгон:</p> <p>1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын "Ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай" 2010 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 300 дугаар тушаалын 2 дахь хэсгийн Ч.Гантуяад холбогдох хэсэг, тус агентлагийн даргын "Ажилд томилох тухай" 2013 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 86 дугаар тушаалыг хууль зүйн үндэслэлгүй гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.</p> <p>2. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Д.Батмөнхөд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний</p>

хэлтсийн Дотоод хяналтын улсын ахлах байцаагчаар ажиллаж байсан Л.Оюунбилэгээс тус агентлагийн даргын “Ажлаас чөлөөлөх тухай” 2014 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 285 дугаар тушаалын өөрт холбогдох хэсгийг эс зөвшөөрч Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, 39.6-д заасныг удирдлага болгон:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын “Ажлаас чөлөөлөх тухай” 2014 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 285 дугаар тушаалын Л.Оюунбилэгт холбогдох 5 дахь хэсгийг хууль зүйн үндэслэлгүй гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.

2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын “Ажлаас чөлөөлөх тухай” 2014 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 285 дугаар тушаалын Л.Оюунбилэгт холбогдох хэсгийг хүчингүйд тооцох.

3. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Д.Батмөнхөд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Дотоод хяналтын улсын ахлах байцаагчаар ажиллаж байсан Л.Оюунбилэгээс тус агентлагийн даргын “Ажлаас чөлөөлөх тухай” 2014 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 285 дугаар тушаалын өөрт холбогдох хэсгийг эс зөвшөөрч Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр

		<p>зүйлийн 39.1.1, 39.5, 39.6--д заасныг тус тус үндэслэл болгон:</p> <p>1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын “Орон тоо шинэчлэн батлах тухай” 2014 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 284 дүгээр тушаалаалын хавсралт дахь Тамгын газрын орлогч дарга, Газрын даргын туслах гэснийг хүчингүй болгохыг тус агентлагийн дарга Д.Батмөнхөд даалгах.</p> <p>2.Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас гарсан тогтоолыг биелүүлж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Д.Батмөнхөд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ